



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ДААЛГАВАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
 Барилгаачдын талбай 13, Засгийн газрын XII байр,
 Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88
 E-mail: info@inspection.gov.mn,
<http://www.inspection.gov.mn>

2019.04.18 № 01/01

ГАЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН
 ХЯНАЛТЫН ГАЗАР, ХИЛИЙН
 МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
 АЛБАНЫ ДАРГА НАРТ

Г Сахилга хариуцлага, дэг журмыг
 чангатгах тухай

Мэргэжлийн хяналтын байгууллагын зарим албан хаагч ажлын хариуцлага алдах, чөлөө зөвшөөрөлгүй хот, хөдөө орон нутагт томилолтоор явах, ёс зүйн хэм хэмжээг зөрчих зэрэг зохисгүй үйлдэл гаргаж байна.

Үүнтэй холбогдуулан дотоод ажлын удирдлага, зохион байгуулалт, сахилга хариуцлагыг сайжруулах, дэг журмыг хангах талаар дараах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга нарт даалгаж байна. Үүнд:

- Хүний нөөцийн үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм журмуудыг чанд мөрдөж, хөдөлмөрийн харилцааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх;
- Ёс зүйн зөвлөл байгуулан Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг зохион байгуулж, албан хаагчдаа зан харилцааны болон ёс зүйн зөрчил, Мэргэжлийн хяналтын байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн аливаа үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлж ажиллах;
- Улсын байцаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулж, хяналт шалгалтын болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу зөв хэрэгжүүлэх чадварыг нь дээшлүүлэх;
- Томилолтоор ажиллах, сургалт зөвлөгөөнд оролцох, спорт, урлагийн арга хэмжээ, аялал зугаалга болон хамт олныг хамруулан зохион байгуулах бусад арга хэмжээний үеэр архидан согтуурах, зүй бус үйлдэл гаргуулахгүй байх;
- Албан хаагчдын цаг ашиглалт, ажлын гүйцэтгэл, үр дүнд байнгын хяналт тавьж, ажил цалгардуулсан, хяналт шалгалтыг дутуу буюу үр дүнгүй хийсэн, иргэн, аж ахуйн нэгжид аливаа байдлаар хүндрэл чирэгдэл учруулсан нь тогтоогдсон албан хаагчид тухай бүр зохих хариуцлага хүлээлгэх;
- Улирлын болон цаг үеийн шинжтэй нөхцөл байдлаас шалтгаалан үүсэх аюул эрсдэлийг зөв тооцоолж, түүнээс урьдчилан сэргийлэх боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллах;
- Нийгэмд анхаарал, шүүмжлэл дагуулсан мэргэжлийн хяналтын байгууллага, ажилтны чиг үүрэгт хамааралтай асуудлыг холбогдох зохих журмын дагуу шуурхай шийдвэрлэж, энэ талаар нийтэд ил тод мэдээлж байх;

8. Байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүн, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим орчинд эрчимтэй сурталчилж байгууллагынхаа үйл ажиллагааны талаар олон нийтийн дунд эерэг хандлага, ойлголтыг төлөвшүүлэхэд онцгой анхаарч ажиллах;

9. Төсвийн сахилга батыг чанд сахиж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр, авлага үүсгэхгүй, санхүүгийн зөрчил гаргахгүй байх;

10. Төсвийн хөрөнгө оруулалтаар барих конторын барилгын ажлын болон бусад худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим хэлбэрээр орон нутагтаа зохион байгуулах;

11. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын зөвшөөрөлгүйгээр УИХ, Засгийн газрын гишүүн, яам, олон улсын болон гадаад улсын байгууллагатай дур мэдэн харилцахгүй байх;

12. Цахим шуурхай хуралд заавал биечлэн оролцож, ажлын тайлан мэдээг товч тодорхой танилцуулан өгсөн үүрэг даалгаврыг ёсчлон биелүүлэх, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Тамгын газрын даргаас урьдчилан чөлөө авахгүйгээр хот, хөдөө орон нутагт явах асуудлыг таслан зогсоох;

13. Энэхүү албан даалгаврыг байгууллагынхаа хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлж, хагас, бүтэн жилээр дүгнэн биелэлтийг 7 сарын 05, 12 сарын 25-ны дотор Тамгын газарт ирүүлж байх.

Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж авах арга хэмжээний санал танилцуулж байхыг Тамгын газар /Ч.Энхбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА, УЛСЫН ЕРӨНХИЙ
БАЙЦААГЧ



И.ЦАГААНХҮҮ